



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/728

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Нийтийн эзэмшлийн “Буянтын боргио” 4 дүгээр байрны айл өрхийн халаалтын босоо шугам солих зардалд зориулж 1 432 000 төгрөг/нэг сая дөрвөн зуун гучин хоёр мянга/-ийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1 432 000 төгрөг/нэг сая дөрвөн зуун гучин хоёр мянга/-ийг аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 3.12 дахь заалтаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ